

БАТЛАВ.



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ ЭРХЭЛСЭН
ПРОРЕКТОР Д.ЦОЛМОНБААТАР

ОЮУТНЫ ГАРААНЫ БИЗНЕСИЙН “MUST STUDENT START-UP 2025” УРАЛДААНЫ
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Зорилго: “MUST STUDENT START-UP” уралдаан нь оюутан, залуусын инновацын соёл хандлагыг төлөвшүүлэх, энтрепренер сэтгэлгээг хөгжүүлэх замаар инженерийн шийдэл, технологи, инновацад суурилсан гарааны бизнесийн санаачилгыг дэмжих зорилготой.

Зохион байгуулалт:

“MUST STUDENT START-UP 2025” уралдаан нь гарааны бизнесийн олон улсын аргачлал (Registration - First screen - Mentor day -Demo day)-ын дагуу явагдана.

Зохион байгуулалтын үе шат	Огноо	
Багуудын бүртгэл:	2025/04/16	QR code болон https://forms.office.com/r/xv8kaXL89g холбоосоор бүртгүүлэх
	2025/05/04	Старт-Ап санаагаа бүрэн тусгасан видео бичлэгийг (2 минутаас хэтрэхгүй) itto@must.edu.mn хаягаар багийн нэр оруулаад бүртгэл хаагдахаас өмнө илгээнэ.
Эхний шатны шалгаруулалт:	2025/05/06	Видео танилцуулгыг үнэлгээний комисс дүгнэж II шатад оролцох багуудыг шалгаруулна.
Энтрепренершип хөтөлбөр (Mentor day):	2024/05/08 2024/05/23	Шалгарсан багуудад чиглүүлэх сургалтууд орно.
Сүүлийн шатны шалгаруулалт (Demo day):	2024/05/26	Үнэлгээний комисс болон олон нийтийн үнэлгээний дунджаар шалгаруулна.

Оролцогчдод тавигдах шаардлага:

- ШУТИС-ийн бакалавр оюутан байх
- 3-5 хүнтэй баг бүрдүүлсэн байх
- Удирдагч багштай байх

Дэвшүүлж буй санаа (Idea), шийдэлд тавигдах ерөнхий шаардлага:

- Тодорхой асуудлыг (problem) шийдвэрлэхүйц бодит шийдэл байх
- Ижил төстэй шийдлээс ялгарах давуу тал, инновац шингэсэн байх
- Шинжлэх ухаан, технологи, бизнесийн шийдэл агуулсан байх
- Зах зээлд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх боломжтой байх
- Бусдын оюуны өмчийг зөрчөөгүй буюу хуулбарлаагүй байх

Шалгаруулалт:

“MUST START-UP 2025” гарааны бизнесийн уралдаан нь 2 үе шаттай (First screen, Demo day) зохион байгуулагдах бөгөөд үе шат тус бүр үнэлгээний шалгуур үзүүлэлт, дүгнэх аргачлалтай байна.

I шатны шалгаруулалт (First screen):

Эхний шатны шалгаруулалтыг ШУТИС-ийн Ректорын тушаалаар батлагдсан уралдаан зохион байгуулах ажлын хэсэг доорх шалгуураар уралдаанд оролцогч багуудаас ирүүлсэн бүртгэлийн мэдээлэл, видео бичлэгт үндэслэн зохион байгуулна.

№	I шатны шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо	Тайлбар
1	Дэвшүүлсэн санаа, шийдлийн шинэлэг байдал	10	Санаа (Idea) нь шинэлэг бөгөөд тодорхой асуудлыг инновацын шийдлээр шийдсэн байх
2	Дэвшүүлсэн санаа, шийдлийн технологийн шийдэл	10	Санаа, шийдэл нь технологи агуулсан бөгөөд түүнийгээ хэрхэн шийдсэн талаарх мэдээлэл
3	Хэрэглээнд нэвтрүүлэх ач холбогдол (Зах зээлийн багтаамж)	10	Зах зээлээ урьдчилан тодорхойлж ирүүлсэн мэдээлэл
	Нийт авбал зохих оноо	30	Багуудыг оноогоор жагсааж боломжит багуудыг II шатанд шалгаруулна.

II шатны шалгаруулалт (Demo day):

Сүүлийн шатны шалгаруулалтыг инновац, старт-ап бизнес, технологийн чиглэлийн туршлагатай төлөөллөөс бүрдсэн комиссын бүрэлдэхүүн багуудын танилцуулга (Pitch)-д үндэслэн доорх шалгуурын хүрээнд дүгнэнэ.

№	II шатны шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо	Тайлбар
1	Дэвшүүлсэн санаа, шийдлийн шинэлэг байдал	10	Санаа (Idea) нь шинэлэг бөгөөд бодиттой асуудлыг шийдвэрлэхүйц шийдэл эсэх
2	Дэвшүүлсэн санаа, шийдлийн технологийн шийдэл	15	Шинжлэх ухаан, технологийн ямар нэгэн шийдэл агуулсан түүнийг шийдсэн талаарх мэдээлэл
3	Бизнес загвар (model) боловсруулсан байдал	10	Санаа, шийдлийг зах зээлд нэвтрүүлэх бизнес загвар боловсруулсан байдал (Үр ашгийн тооцоо бодиттой эсэх)
4	Танилцуулга (Pitch) ойлгомжтой байдал	5	Танилцуулга бүрэн ойлгомжтой бөгөөд хугацааг баримталж байгаа байдал
5	Олон нийтийн үнэлгээ*	10	Видео танилцуулгыг ШУТИС-ийн цахим хуудсаар дамжуулан түгээж харгалзах үзэлтэнд үндэслэж оноо тооцно.
	Нийт авбал зохих оноо	50	Багуудыг оноогоор жагсааж эхний 3 багт урамшуулал олгоно.

*Олон нийтийн үнэлгээг тооцох аргачлал: Цахим сүлжээ(facebook)-нд байрлуулсан багуудын видео танилцуулгад олон нийтээс өгсөн үнэлгээ (like, organic view)-нд үндэслэнэ.

Шагнал, урамшуулал:

- Уралдааны хоёрдугаар шатанд шалгарсан багуудыг “Энтрепренершип” хөтөлбөрт хамруулж гэрчилгээ олгоно.
- Сүүлийн шат (Demo day)-нд шалгарсан багуудад санаагаа хөгжүүлэх зорилгоор дараах байдлаар шагнал олгоно.
 - I байр – 4.000.000 төгрөг
 - II байр – 3.000.000 төгрөг
 - III байр – 2.000.000 төгрөг
 - Тусгай байр 500.000 төгрөг (2 баг)

Зохион байгуулагч:

ШУТИС-ийн Инновац, бизнес түншлэлийн алба

--oOo--